БАТЛАВ:

ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ Ц.ТӨМӨР-ОЧИР

УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ХҮНСНИЙ БАРААНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ-2023 он

Нийлүүлэгдэх бараа бүтээгдэхүүн нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, стандартын шаардлагад нийцсэн байна.

Багцын дугаар	Хүнсний барааны нэр төрөл	Стандарт	Тодорхойлолт
Багц №1	Мах, махан бүтээгдэхүүн	**Хонины мах**: Монгол улсын стандарт "Гулууз махны техникийн ерөнхий шаардлага" MNS1111:2009. Эрүүл ахуйн аюулгүй байдлын үндсэн шаардлага – MNS 5023:2001.	Тухай бүр малын гарал үүслийн гэрчилгээтэй, мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний дүгнэлттэй. Стандартын дагуу бэлтгэсэн 1 ба 2-р зэргийн, өөрийн өвөрмөц өнгөө хадгалсан, махны тод улаан өнгөтэй, цусны толбогүй, үнэрийн өөрчлөлтгүй, бүрэн бүтэн, ясны гэмтэлгүй, үс хялгасгүй цэвэрлэгдсэн, гадаргуу цэвэр хуурай, загсаалтын хальстай, хуруугаар дарсан хонхорхой арилдаг, өөх нь цагаан, үл мэдэг шаргал туяатай, хатуу бүтэн ястай мах байх
		Үхрийн мах: Эрүүл ахуйн аюулгүй байдлын үндсэн шаардлага - MNS 5023:2001, "Үхрийн хэсэглэж ангилсан махны техникийн шаардлага" MNS 2456:2009	-Тухай бүр малын гарал үүслийн гэрчилгээтэй, мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний дүгнэлттэй. Стандартын дагуу бэлтгэсэн 1 ба 2-р зэргийн, өөрийн өвөрмөц өнгөө хадгалсан, махны тод улаан өнгөтэй, цусны толбогүй, үнэрийн өөрчлөлтгүй, гадаргуу цэвэр хуурай, загсаалтын хальстай, өөх нь цагаан шаргал ясгүй мах байх
		Тахианы хэсэглэж ангилсан мах. MNS 0703:2014. (Энэхүү стандарт нь махны чиглэлийн тахианы мах үйлдвэрлэх, импортлох, экспортлох, шалгаж хүлээн авах, зах зээлд нийлүүлэх, савлах, шошголох, хадгалах,	-Тухай бүр гарал үүслийн гэрчилгээ, эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний дүгнэлттэй байна. Биет байдал нягт, гадаргуу нь цэвэрхэн, арьсанд цус хураагүй, эмгэгтөрөгч, хөгц илрээгүй, гадны хольцгүй, үнэргүй, арьсны өнгө бага зэрэг хөхөвтөр туяатай байна. Бүтээгдэхүүн нь мэдрэхүйн эрхтний үнэлгээ, физик химийн үзүүлэлт, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шалгуур үзүүлэлт, аюулгүй байдлын үзүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн шаардлагыг

		тээвэрлэхэд хамаарна.) Үүнд: **тахианы цээж мах, тахианы гуяны цул мах, тахианы мөч** зэрэгт хамаарна.	хангасан байх
		Амьтны гаралтай бусад бүтээгдэхүүн: Үхрийн гүзээ Хүнсний зориулалттай дайвар түүхий эд бүтээгдэхүүний техникийн шаардлага MNS 1023:2007 (энэхүү стандарт нь мал, амьтны дотор мах, дайвар түүхий эд болон тэдгээрийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, савлах, шошголох, шалгаж хүлээн авах, хадгалах, тээвэрлэхэд хамаарна.)	- Тухай бүр гарал үүслийн гэрчилгээ,мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээний дүгнэлттэй байна. Улирлын байдалд тохируулан захиалан авна. Гэдэс дотрыг бүрэн цэвэрлэсэн. Муудаагүй, элдэв үнэргүй, дотор өөхгүй, шинээр нь болон хөлдөөсөн байж болно.
		Ясгүй загасны мах: олон улсын стандартын үзүүлэлтийг хангасан байна.	Импортын бараа бүтээгдэхүүн нь үйлдвэрийн сертификаттай байх, Хагас боловсруулсан байдлаар бэлтгэсэн, халуун боловсруулалт хийхэд бэлэн, биет байдлаа алдаагүй мөсөөр хучигдсан, гадны хольцгүй, бүтээгдэхүүний шинэлэг байдал алдагдаагүй байх
		Чанамал ба утлагат махан бүтээгдэхүүн: MNS 0108:2019 Бэлэн бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг хангасан байна.	Стандартад заасан шаардлагыг хангасан, мэдрэхүйн эрхтний үнэлгээ, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шалгуур үзүүлэлт, физик-химийн үзүүлэлтийг хангасан байх. Тухай бүр шинжилгээний дүгнэлттэй байх
		Сүү, тараг: MNS 0219:2011	Үндэсний үйлдвэрийн тохирлын гэрчилгээтэй, үйлдвэрийн бүтээгдэхүүн байх. Сав баглаа боодол, шинэхэн, үйлдвэрлэсэн хугацаа, хадгалалтын горим тодорхой, орц найрлага нь ойлгомжтой бичигдсэн, бүрэн бүтэн, нэмэлт баяжуулагчтай бол тухайн бүтээгдэхүүний амт үнэртэй, гадны амт үнэргүй, үйлдвэрийн шинжилгээний бичигтэй бүтээгдэхүүн байх.

Багц 2	Сүү, сүүн бүтээгдэхүүн	**Цөцгийн тос- MNS 6652:2017**	Үйлдвэрийн аргаар боловсруулсан, эх орны үйлдвэрийнх бол тохирлын гэрчилгээтэй, үйлдвэрийн бүтээгдэхүүн байх, импортын бүтээгдэхүүн бол бараааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байна. Цайвар шаргал өнгөтэй, нэр төрөлдөө тохирсон үнэр, амттай, гадны механик хольцгүй, нян, хөгц, мөөгөнцөр илрээгүй, транс тосны агууламжгүй. Мөнгөлөг пергамент цаасанд жижиглэн савласан, нэг удаагийни шууд хэрэглээгээр байх. Аюулгүй байдлын үзүүлэлт стандартад заасан хэмжээнд байх.
		Уураглаг цагаан идээ Аарц MNS 4230:2005	Техникийн ерөнхий шаардлага хангасан. Гарал үүсэл нь тодорхой, цагаан цайвар шаргал өнгөтэй, нэр төрөлдөө тохирсон бага зэргийн исгэлэндүү, өөрийн өвөрмөц үнэртэй, шар сүүний ялгарал багатай, жигд дунд зэргийн нягтрал бүхий зөөлөн биет байдалтай, бутрамхай байх. Шинжилгээний дүгнэлттэй, стандартын шаардлага хангасан, хэт исгэлэн гашуун ахарсан, хөгцөрсөн биш байх.
Багц 3	Өндөг	**Өндөг: MNS 3244:1989**	Үндэсний үйлдвэрийн тохирлын гэрчилгээтэй байх, импортын бараа бол үйлдвэрийн сертификаттай бүтээгдэхүүн байх. Савлалт нь шинэхэн, стандартын шаардлага хангасан, өндөгний хальс нь бүрэн бүтэн, шохойн бүрхүүл нь гэмтээгүй, цэвэр байх. Лавлагаа лабораторийн шинжилгээний бичигтэй байх.
Багц 4	Талх талхан бүтээгдэхүүн	**Талх: Техникийн ерөнхий шаардлага MNS4661:2009** Үүнд: Буудайн гурилын талх буюу цагаан талх, хөх тарианы гурилын талх буюу хар талх хамаарна.	Үндэсний үйлдвэрийн тохирлын гэрчилгээтэй, үйлдвэрийн бүтээгдэхүүн байх, баглаа боодол бүрэн бүтэн, үйлдвэрлэсэн болон хадгалалтын горим тодорхой, орц найрлага нь ойлгомжтой бичигдсэн байх.

		Жигнэмэг: MNS 0158:1985	Үндэсний үйлдвэрийн тохирлын гэрчилгээтэй, үйлдвэрийн бүтээгдэхүүн байх, баглаа боодол бүтэн, гэмтээгүй, үйлдвэрлэсэн хугацаа, хадгалалтын горим тодорхой, орц найрлага нь ойлгомжтой бичигдсэн, 50гр-аар савлагдсан, нэг удаагийн цайнд өгөх бүтээгдэхүүн байх
Багц 5	Гурил	**Улаан буудай гурил – MNS 0244:2009** Энэхүү стандарт нь буудайн гурилыг хүнсний зориулалтаар төрөлжүүлэн үйлдвэрлэх, шалгаж хүлээн авах, борлуулах, хадгалах, хэрэглэх, тээвэрлэхэд хамаарна.	Үйлдвэрлэлийн болон сав баглаа боодол, тээвэрлэлтийн стандартыг хангасан, эх орны үйлдвэрийн, бүтээгдэхүүний үндэсний тохирлын гэрчилгээтэй байх, гадны механик хольц, элдэв үнэр амтгүй, хөгцөрч муудаагүй, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй, Дээд,1,2-р зэргийн тэмдэгтэй, 25-50 кг-аар савлагдсан байх.
			Бүхэл үрийн гурил нь улаан буудайг хальстай тээрэмдэж гаргаж авна. Дээрхи технидийн шаардлагыг хангасан байна.
Багц 6	Будаа, үр тариан бүтээгдэхүүн	**Хүүхдийн будаа - MNS 0243:2003**	Үйлдвэрийн аргаар боловсруулсан эх орны болон импортын барааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байх. Хүнсний аюулгүй байдал, хорио цээрийн шаардлагыг хангасан, чийг аваагүй, бөөгнөрөөгүй, хөгцрөөгүй, химийн болон биологийн бохирдолгүй байна. Сав баглаа боодол, савлалтын хэмжээ өргөж буулгахад даагдахуйц, стандартын шаардлага хангасан байх.
		Гоймон – MNS 0142:1985	Үйлдвэрийн аргаар боловсруулсан эх орны болон импортын барааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, Өндөгний хольцтой, урсамтгай биш шинж чанартай, чийг алдаагүй, хөгцөрч муудаагүй, үүрч гэмтээгүй, хэлбэр дүрсээ алдаагүй байх, лабораторийн шинжилгээний дүгнэлтээр хүчиллэг, чийг, хүнд металлын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд, эмгэгтөрөгч, нян илрээгүй байх, сав баглаа боодол, тээвэрлэлтийн стандартын шаардлага хангасан байх. 5-аас доошгүй төрөл байж болно. /туузан (өргөн), мушгиа, шпагети, дун, хөндий, лапша (луувантай, сонгинотой) г.м/

		Шар будаа - MNS 0533:1998, ГОСТ 572-60	Үйлдвэрийн аргаар боловсруулсан импортын барааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байх. Үйрч бүтраагүй, цавуулагын хэмжээ стандартад заасны дагуу, өнгө нь тунгалаг шар, ширхэг нь хэт жижиг биш байна. Сав баглаа боодол, савлалтын хэмжээ өргөж буулгахад даагдахуйц, тээвэрлэлтийн стандартын шаардлага хангасан байх.
		Цагаан будаа - MNS ISO 7301:2000, ГОСТ 0292-93	Үйлдвэрийн аргаар боловсруулсан импортын барааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байх. Харлаж цоохортоогүй, хөгцний амт үнэргүй, хортон мэрэгч шавьж, тэдгээрийн өт, авгалдай, ялгадасаар бохирлогдоогүй байна. Том ширхэгтэй, цагаан будааны тоос, буталсан үрийн хэсэггүй байна. Өнгө нь хэт цагаан биш, гэхдээ шарласан туяагүй байна. Дунд үрийн 5-6 мм хэмжээтэй. Сав баглаа боодол, савлалтын хэмжээ өргөж буулгахад даагдахуйц, тээвэрлэлтийн стандартын шаардлага хангасан байх.
		Хөц будаа - MNS 4515:2010, ГОСТ 5784-60	Үйлдвэрийн аргаар боловсруулсан импортын барааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байх. Сайн зүлгэгдсэн, жигд гөлгөр гадаргуутай, зөв бөөрөнхийдүү хэлбэртэй, пестицидын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнд, будааны өөрийн үнэртэй, исгэлэн гашуун гадны үнэр, амтгүй байх. Сав баглаа боодол, савлалтын хэмжээ өргөж буулгахад даагдахуйц, тээвэрлэлтийн стандартын шаардлага хангасан байх.
		Гурвалжин будаа MNS 6511:2015,	Үйлдвэрийн аргаар боловсруулсан импортын барааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байна. Шаравтар болон бор туяатай цайвар өнгөтэй. Будааны өөрийн үнэртэй, исгэлэн гашуун гадны үнэр, амтгүй байх. Эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлт нь стандартад заасан хэмжээнээс хэтрээгүй байна. Сав баглаа боодол,

			савлалтын хэмжээ өргөж буулгахад даагдахуйц, тээвэрлэлтийн стандартын шаардлага хангасан байх.
		Хатаасан вандуй	Үйлдвэрийн аргаар боловсруулсан импортын барааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байна. Хатаасан вандуйны өөрийн үнэр, зөөлөн амттай, исгэлэн гашуун гадны үнэр, амтгүй, харлаж цоохортоогүй, хөгцний амт үнэргүй, хортон мэрэгч шавьж, тэдгээрийн өт, авгалдай, ялгадасаар бохирлогдоогүй байна. Хэлбэр дүрсээ алдаагүй, үйрч бутраагүй, сав баглаа боодол, савлалтын хэмжээ өргөж буулгахад даагдахуйц, тээвэрлэлтийн стандартын шаардлага хангасан байх.
		Хүнсний давс - MNS CAC 150:2007.	1-кг-аар савлагдсан, физик химийн үзүүлэлтийг хангасан, эрдэс бодисын баяжмалтай, сав баглаа боодлын шошгололтын стандарт шаардлагыг хангасан, монгол тайлбартай бүтээгдэхүүн байна. (Давсны амт, эрдэсийн агууламж тодорхой байх) Давсанд агуулагдах хүнд металлууд болон хүнсний нэмэлт нь стандартад заасан хэмжээнээс хэтрээгүй байх. Бөөгнөрч чийг аваагүй, хатуураагүй, сав баглаа боодол нь битүүмжлэл сайтай, эх орны үйлдвэрийнх бол бүтээгдэхүүний үндэсний тохирлын гэрчилгээтэй, импортынх бол дагалдах сертификаттай байх. Сав баглаа боодол, савлалтын хэмжээ өргөж буулгахад даагдахуйц, тээвэрлэлтийн стандартын шаардлага хангасан байх.
		Элсэн чихэр - MNS CAC 212:2014	Үйлдвэрийн аргаар боловсруулсан импортын барааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байх. Цагаан болон бор өнгөтэй, чийггүй, бөөгнөрч хатуураагүй, шарлаагүй, бөөгнөрөхөөс сэргийлсэн бодис нэмээгүй, хүнд металл болон пестицидийн үлдэгдэл стандарт хэмжээнээс хэтрээгүй байх. Сав баглаа боодол, савлалтын хэмжээ өргөж буулгахад даагдахуйц, тээвэрлэлтийн стандартын шаардлага хангасан байх.

		Пүнтүүз - MNS 0362:1982	Үйлдвэрийн аргаар боловсруулсан эх орны болон импортын барааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байх. Өөрийн өвөрмөц амттай, хөхөвтөр цайвар, цувимал бөөрөнхий гөлгөр жигд гадаргуутай, гадны хольцгүй, чанаж болгоход уян нарийхай шинж чанараа хадгалсан байна. 0,3-1кг аар савлагдсан, баглаа боодол бүрэн бүтэн, үйлдвэрлэсэн болон хадгалалтын огноо тодорхой бичигдсэн байх.
Багц 7	Нөөшилсөн бүтээгдэхүүн	**Нөөшилсөн бүтээгдэхүүнд тавих нийтлэг шаардлага**: Багцад заасан нөөшилсөн бүтээгдэхүүн нь үйлдвэрийн аргаар боловсруулсан, эх орны болон импортын барааны стандартын шаардлага хангасан, дагалдах сертификаттай, хадгалалт, нийлүүлэлтийн явцад бүтээгдэхүүн тус бүрийг тодорхой үзүүлэлтээр улирал бүр лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байх. үйлдвэрлэгдсэн болон хадгалалтын хугацаа тодорхой заагдсан, шошгын мэдээлэл бүрэн, монгол заавартай, лаазалсан бүтээгдэхүүний лаазны таглаа татуурган онгойлгогчтой, хайрцаг сав нь бүрэн бүтэн, хонхойж гэмтээгүй байх. Шингэн бүтээгдэхүүн нь тунадас үүсээгүй, тухайн бүтээгдэхүүний тохирсон үнэртэй. Нөөшилсөн варень, жимс нь өөрийн үнэр амттай, гадаргуу биет гэмтэлгүй, хортон шавьжны бохирдолгүй, чихрийн талстгүй байх.	
		Ургамлын тос – MNS 6646:2016:	Үйлдвэрийн аргаар боловсруулсан импортын барааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байх, Хүнсэнд шууд хэрэглэх ба халуун ажиллагаанд ашиглах зориулалтай, сав нь бүрэн бүтэн, үнэргүй, нэр төрөлдөө тохирсон сул амттай, тунадасгүй тунгалаг шар өнгөтэй бүтээгдэхүүн байх
		Цөцгийн тос - MNS 6652:2017	Үйлдвэрийн аргаар боловсруулсан импортын барааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байна. Цайвар шаргал өнгөтэй, нэр төрөлдөө тохирсон үнэр, амттай, гадны механик хольцгүй, нян, хөгц, мөөгөнцөр илрээгүй, транс тосны агууламжгүй. Аюулгүй байдлын үзүүлэлт стандартад заасан хэмжээнд байх. Картон цаасан хайрцаганд 20кг-аар савлагдсан, 82% тослогтой бүтээгдэхүүн байх.

		Оливын тос - MNS CAC 125:1998	Үйлдвэрийн аргаар боловсруулсан импортын барааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байх, Элдэв үнэр амтгүй, тослогийн хэмжээ стандартын шаардлага хангасан байна. Зориулалтын сав баглаа боодолтой байх.
		Майонез - MNS CAC 168:1999 **ГОСТ Р 53510-2009.**	Үйлдвэрийн аргаар боловсруулсан эх орны болон импортын барааны стандартын шаардлага хангасан дагалдах сертификаттай, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй бүтээгдэхүүн байх. Зориулалтын сав, баглаа боодолтой, хадгалалтын хугацаа болон үйлдвэрлэсэн хугацаа тодорхой, өөрийн өвөрмөц үнэртэй. Шаргал өнгөтэй, нэгэн төрлийн бие бүтэцтэй, булингар, тунадас үүсээгүй, хөлдөөгүй байх.
		Ногооны нөөш - MNS 5075:2001 **Савласан бүтээгдэхүүний стандарт** **MNS (CAC)1:2007** **Ногоон шар шошны нөөш - MNS CAC 113:1999**	Дээр заасан нөөшилсөн бүтээгдэхүүнд тавих нийтлэг шаардлагыг хангасан байх.
		Лаазалсан улаан лоолийн нухаш – MNS CAC 13:1995	Улаан хүрэн өнгөтэй, өтгөн, нэр төрөлдөө тохирсон амт, үнэртэй байх.
		Хоол амтлагч-MNS 5519:2005 **/Роллтонтой дүйцэхүйц/**	Заасан стандартын шаардлагыг хангасан байна. Монгол тайлбартай, химийн нэмэлт бодисгүй, ургамлын гаралтай бүтээгдэхүүн байх
		Монгол цуу - MNS 1117:1980	Заасан стандартын шаардлагыг хангасан байх.
		Жимсний чанамал - MNS 4765:99 Варень:	Эрүүл ахуйн болон нөөшилсөн бүтээгдэхүүнд тавих нийтлэг шаардлага хангасан байна. Усжаагүй, исээгүй, элдэв үнэр амтгүй байх
		Хүнсний желатин - MNS 4119:1992	Заасан стандартын шаардлагыг хангасан байх.
		Жимстэй цай, ногоон цай–MNS 67.140.10	

		Кофе – MNS 67.140.20 **Ёотон – MNS 5410:2004** **Зөөлөн чихэр – MNS 0444:1987** **Хатуу чихэр – MNS 0395:1987** **Жигнэмэг – MNS 0158:1985** **Жүүс – MNS 0687-1:2012** **Цэвэр ус, 0.33 – MNS 5007:2007**	Заасан стандартын шаардлагыг хангасан байх.
Багц 8	Хүнсний үндэс үрт ногоо, Жимсгэнэ	**Нийтлэг шаардлага**: Жимс жимсгэнэ нь гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүгнэлттэй байх. жимсгэнэ нь мэдрэхүйн үзүүлэлтээр бүтцийн өөрчлөлтгүй, бараа нь өөрийн амт үнэрээ хадгалсан, гадны бохирдолгүй, шинэхэн, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг хангасан байх. Бүтээгдэхүүнийг хурц үнэртэй өөр төрлийн бараатай хамт тээвэрлээгүй байх. Түргэн гэмтдэг хүнсний барааг тусгай зориулалтын машинаар чанарыг алдагдуулахгүйгээр, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан орчин нөхцөлд хадгалах ба тээвэрлэлтийн шаардлагыг хангасан байх	
		Шар лууван - MNS 0270:2020 **Төмс - MNS 0258:2021** **Бөөрөнхий байцаа MNS 0255:2020** **Бөөрөнхий сонгино - MNS 0260:2022** **Улаан манжин - MNS 0269:2020** **Бөөрөнхий улаан байцаа - MNS 0255.:2020**	Монголын орны хөрсөнд тарьсан, эрүүл ахуйн болон ариун цэврийн шаардлага хангасан баглаа боодолтой. Хортон шавьж, хачиг, авгалдай илрээгүй, бие бүтэц нь бүтэн, хөгцөрч муудаагүй, хөлдөөгүй, ялзраагүй, хатаж хорчийгоогүй, ургамлын хорио цээрийн шаардлага хангасан, гарал үүслийн гэрчилгээ, шинжилгээний дүгнэлттэй, хадгалалтын горим алдагдаагүй, үндэс үрт, хүнсний ногоог нийлүүлэх MNS /ISO/ 7563:2000 MNS 4504-1997. Заасан стандартын шаардлагыг хангасан, хүнсний аюулгүй байдал, хорио цээрийн шаардлагыг хангасан байх. Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицид, хүнд металл, нитратын зөвшөөрөгдөх дээд хэмжээ зэрэг нь Монгол улсын зөвшөөрөгдсөн стандартад заасан хэмжээнээс ихгүй байх
		Сармис - MNS 0267: 2022 **Улаан лооль - MNS 0264:2009** **Амтат чинжүү - MNS**	Хүнсний нарийн ногоо нь цэвэр хэлбэр дүрсээ алдаагүй, хортон шавьж мэрэгч, хачиг, авгалдай илрээгүй, хөгцөрч

Багц 9	Жимс, нарийн ногоо	**0279:1982** **Өргөст хэмх -MNS ISO 7560:2002** **Цэцэгт байцаа -MNS 0257:2020** **Буурцай -MNS 0274:1982** **Салат навч-MNS 0277:1982** **Шанцай -** **Урт сонгино- MNS 0259:2018**	муудаагүй, ялзраагүй, ургамлын өөрийн үнэр амттай, хөлдөөгүй, хатаж чийгээ алдаагүй, ургамлын хорио цээрийн шаардлага хангасан, гарал үүслийн гэрчилгээ, шинжилгээний дүгнэлттэй, заасан стандартын шаардлагыг хангасан байх, хадгалалт болон тээвэрлэлтийн горим зөрчигдөөгүй бүтээгдэхүүн байх, Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицид, хүнд металл, нитратын зөвшөөрөгдөх дээд хэмжээ зэрэг нь Монгол улсын зөвшөөрөгдсөн стандартад заасан хэмжээнээс ихгүй байх
		Нөөшилсөн жимс, хүнсний ногоо нь эрүүл ахуйн дадлын дүрэм MNS CAC RCP: 2014 стандартыг хангасан байна **MNS /ISO/ 874: 2000, MNS 2829:79.** **Алим -MNS CAC 299:2014 Жимс - MNS 67: 080** **Тарвас - MNS 0281:1982** **Амтат гуа - MNS 0282:1982** **Жимсээр хийсэн бүтээгдэхүүн - MNS 67:080.10** **Үзэм - MNS4765:99** **Чацаргана жимс - MNS 0916:2011** **Үхрийн нүд жимс - MNS 1989:2013** **Хан борогцойн нөөш - MNS CAC 52:1999**	Жимс, жимсгэнэ - нь хэлбэр дүрсээ алдаж гэмтээгүй, гүйцэт боловсорсон, зөөлөн эд нь нягт хатуу байдалтай, зөв хэлбэр дүрстэй, хортон шавьж мэрэгч, хачиг, авгалдай илрээгүй, хөгцөрч муудаагүй, ялзраагүй, гадны амт үнэргүй, жимсний өөрийн өвөрмөц үнэр амттай, хөлдөөгүй, хатаж чийгээ алдаагүй, ургамлын хорио цээрийн шаардлага хангасан, гарал үүслийн гэрчилгээ, шинжилгээний дүгнэлттэй байх. Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицид, хүнд металл, нитратын зөвшөөрөгдөх дээд хэмжээ зэрэг нь Монгол улсын зөвшөөрөгдсөн стандартад заасан хэмжээнээс ихгүй байх

Багц 10	Нэг удаагийн сав хэрэгсэл	**Хоолны хэрэгсэл**	Хүнсний нэг удаагийн сав хэрэгсэл (хоолны сав, аяга, халбага, сэрээ) нь хүнсний бараа бүтээгдэхүүнтэй шууд харьцах гадаргуутай байх, дотоодын үйлдвэрт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн бол үйлдвэрийн тохирлын гэрчилгээтэй байх. Хоолны савны хэмжээ 0,75мл байх.
		Хүнсний туузан наалт буюу скоч, хүнсний уут, хүнсний бээлий	-Хүнсний өнгөгүй туузан наалт нь хүнсний бараа бүтээгдэхүүнтэй шууд харьцах гадаргуутай байх, ороолтын хэмжээ 20-35мм зузаантай, өргөний хэмжээ 40-45 см, хүнсний эрүүл ахуйн чанарын шаардлагыг хангасан байх, Хүнсний тасалдаг уут нь эрүүл ахуйн шаардлага хангасан, хүнсний бараа бүтээгдэхүүнтэй шууд харьцах гадаргуутай, хэт нимгэн биш, ороолтын зузаан нь хэрэглээнд тохирохуйц байх -Хүнс үйлдвэрлэлд зориулсан бээлий нь хүнсний бараа бүтээгдэхүүнтэй шууд харьцах гадаргуутай, L размер, хүний арьсанд харшил өгөхгүй, баглаа боодол нь битүүмжлэлтэй байх
		Цаасан гарын болон амны алчуур	-цаасан сальфетканууд нь ам арчих, гар арчих, гал тогооны зориулалттай, ам болон гар арчихад хөвөнлөг утас тасарч үлдэхгүй, тоосорч бужигнахгүй эрүүл ахуйн шаардлага хангасан байх
		Калькан болон тугалган цаас	Эдгээр нь эрүүл ахуйн болон баглаа боодлын шаардлага хангасан импортын бараа бүтээгдэхүүн байх